



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮН,
БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

2026.01.14 № 02

**Боловсролын зээлийн сангийн
тэтгэлгээр суралцагчдын талаар**

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2 дахь Эрдэм боловсролтой монгол хүн зорилтын 2.2.2.8-д “Ерөнхийлөгчийн илгээлт 2100 тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.” гэж заасан. Энэ дагуу Засгийн газраас “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”-ын 4 дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг олгох талаар тусгайлан зохицуулж, энэхүү тэтгэлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад тус тус заасныг үндэслэн уг тэтгэлгийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, цаашид тухайн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх санал боловсруулах, Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 оноос хойших хугацаанд хамаарах дараах асуултыг тавьж байна.

Ерөнхийлөгчийн тэтгэлгийн хүрээнд:

1.Ерөнхийлөгчийн тэтгэлгээр гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо, суралцаж буй боловсролын түвшин, тэтгэлэгт зарцуулсан санхүүжилтийн нийт дүн;

2.Ерөнхийлөгчийн тэтгэлгээр гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын суралцаж буй сургуулиудын олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний дундаж эрэмбэ;

3.Ерөнхийлөгчийн тэтгэлгээс татгалзсан, тэтгэлэг цуцлагдсан суралцагчдын тоо, шалтгаан;

Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадын сургалтын байгууллагад суралцагчдад олгож буй тэтгэлэг, хөнгөлөлтийн хүрээнд:

1.Боловсролын зээлийн сангийн тэтгэлэг, хөнгөлөлттэй зээлээр бакалавр, магистр, докторын түвшинд суралцагчдын сурлагын дундаж үзүүлэлт, сурлагын талаарх мэдээлэл;

2026000004


2.Бакалавр, магистр, докторын түвшинд тэтгэлэг, хөнгөлөлттэй зээлээр суралцах хүсэлт гаргасан, хамрагдсан, татгалзсан болон цуцлагдсан иргэдийн тоо, мөн тэтгэлэг, хөнгөлөлттэй зээлээр суралцаж төгсөөд Монгол Улсад эргэн ирж ажиллаж байгаа болон эргэн ирээгүй суралцагчдын тоо;

3.Боловсролын зээлийн сангийн тэтгэлэг, хөнгөлөлттэй зээлээр суралцаж Монгол Улсад эргэн ирсэн суралцагчдын ажиллаж буй байгууллагын төрөл /Төрийн байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага гэх мэт/;

4.Боловсролын зээлийн сангийн тэтгэлэг, хөнгөлөлттэй зээлээр гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын түвшинд суралцагчдын тоо, тэтгэлэг, хөнгөлөлттэй зээлд зарцуулсан санхүүжилтийн нийт дүн болон суралцагчдын зээлийн эргэн төлөлтийн хувь, боловсролын зээлийн санд төвлөрүүлсэн зээлийн эргэн төлөлтийн хэмжээ зэрэг болно.

Дээрх асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ЦЭНГҮҮН

2026000004